



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/240

Чингис хот

Төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төр-Иргэний нийгмийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох зорилгоор Хэнтий аймгийн хэмжээнд зохион байгуулж буй Төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгаа гаргах, цахим бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулж байгаа аймгийн Иргэний нийгмийн байгууллагын сүлжээний үйл ажиллагаанд 2.000.000 /хоёр сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрөөр хийгдэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Судалгааны ажлын төсвийн задаргаа

№	Зардал	Хэмжих нэгж	Тоо	Үнийн дүн	Нийт дүн	Тайлбар
1	Судалгааны асуумж боловсруулах, хэлэлцүүлэг	Хүн	10	250,000.00	500,000.00	Судалгааны асуумж боловсруулалт, хэлэлцүүлэгт шаардлагатай 2 удаа*10 хүний бичиг хэрэг, цайны зардал
2	Бичиг хэрэг	-	-	100,000.00	100,000.00	Судалгаанд шаардагдах бичиг хэргийн зардал
3	Интернет, утас	Сар	2	100,000.00	200,000.00	Судалгааг нэгтгэх, судалгааг цахимжуулна.
4	Судалгааг нэгтгэх, цахимд оруулах	-	-	100,000.00	100,000.00	Судалгааг нэгтгэх, цахимжуулалт хийх
5	Цайны материал	Сар	2	50,000.00	100,000.00	Судалгааны багийн гишүүдийн уулзалтын цайны материал
5	Судалгааны багийн гишүүдийн урамшуулал	Хүн	5	100,000.00	1,000,000.00	Судалгаанд явах багийн 5 гишүүний 2 сарын урамшуулал
Нийт дүн					2,000,000.00	